



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/790

Булган сум

Аймгийн аюулгүйн нөөцөд өвс, тэжээл  
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/609 дүгээр “Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын нийлүүлэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-ний нийлүүлэх 15000 боодол өвс, 60 тн тэжээлийг гэрээнд туссан байршлуудад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч дарга)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Б.Одхүү (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-  
ийн захирал)

2.Өвс, тэжээлийг хүлээн авч, хадгалалт, хуваарилалтыг хариуцаж ажиллахыг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК (Б.Одхүү)-д, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, баримт материал бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010934